

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны
01 дугаар сарын 13-ний өдрийн 4/ дугаар
тушаалын 15 дугаар хавсралт 104

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Гэрээний дугаар:	2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эдийн засаг, хөгжлийн яам
3. Орон тоо, албан тушаал: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Байгаль орчин, уур амьсгалын асуудал хариуцсан мэргэжилтэн	
4. Ажлын байрны шууд харьяалах удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төслийн зохицуулагч, дэд зохицуулагч нар	

Б. ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны үндсэн зорилго:	Төслийн Хөгжлийн түншүүдийн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн хамгаалалтын бодлогын арга хэмжээнүүдийг дагаж, мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулах, төслийн бүх бүрэлдэхүүн хэсгүүдэд уур амьсгалд дасан зохицох байдлыг нэмэгдүүлэх, байгаль орчны менежмент, дасан зохицох чиглэлээр орон нутгийн оролцогч талуудын чадавхыг нэмэгдүүлэх, нүүрстөрөгч багатай бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх болон нүүрстөрөгчийн тухай суурь ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой. Нүүлгэн шилжүүлэлтийн бүхий л үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хариуцаж, зорилтот аймгуудын газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, хэрэгжилтийг хангаж ажиллана.
2. Ажлын байрны дэд зорилтууд:	4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бүхий л үйл ажиллагааны гол асуудлуудыг шийдвэрлэж, Хөгжлийн түншүүдийн байгаль орчны хамгаалалтын бодлогын арга хэмжээ, хамгаалалтын бодлогын баримт бичгүүд болон Монгол улсад хэрэгжиж хууль тогтоомж, холбогдох бусад дүрэм, журам стандартуудын нийцлийг хангах. 5. Аймаг, сумын төвийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон дэд бүтцийг сайжруулах замаар уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өртөмтгий байдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас Монгол Улсын бэлчээрийн өгөөж буурах асуудлыг шийдвэрлэхэд Мал аж ахуй /МАН/ -н салбарт дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. 6. АХБ-ны Хамгаалалтын бодлогын мэдэгдэл [SPS] (2009) болон бусад Хөгжлийн түншүүдийн дотоодын хууль тогтоомж, орон нутгийн шаардлагын дагуу нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх;

	7. Нүүлгэн шилжүүлэлтийн асуудал, холбогдох мэдээлэл цуглуулах талаар аймаг, сумын дарга, холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах; 8. Гомдол барагдуулах механизмын хөтөлбөрийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх; 9. Газар чөлөөлөлтийн ажлыг багасгах, зайлсхийх зэрэг шаардлагатай бүх ажлыг хийх; 10. Газар чөлөөлөлтийн үйл явц, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.		
11. Ажлын байрны үндсэн үйл ажиллагаа:	Хугацаа/ хуваарь	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
45. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бүхий л үйл ажиллагааны гол асуудлуудыг шийдвэрлэж, Хөгжлийн түншүүдийн байгаль орчны хамгаалалтын бодлогын арга хэмжээ, Хамгаалалтын бодлогын баримт бичиг болон Монгол улсад хэрэгжиж хууль тогтоомж, холбогдох бусад дүрэм, журам стандартуудын нийцлийг хангах. 46. Байгаль орчны үнэлгээнүүдийг чиглүүлж, нөлөөллийг бууруулах төлөвлөгөөнд хяналт тавих. 47. Хөгжлийн түншүүдэд байгаль орчны шаардлагад нийцсэн байдал, уур амьсгалд дасан зохицох үйл ажиллагааны тайланг бэлтгэх. 48. Байгаль орчны доройтлыг багасгаж, биологийн олон янз байдлыг дэмжсэн хөдөө аж ахуйн үйл ажиллагааг дэмжих, хөдөө аж ахуйн бүтээмж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх, дасан зохицох чадварыг сайжруулахын тулд хөрс, усыг хамгаалах арга техникийн талаар техникийн зөвлөгөө өгөх. 49. Байгаль орчны тогтвортой байдал, уур амьсгалд тэсвэртэй байдал буюу дасан зохицох чадварыг сайжруулахын тулд хот байгуулалтын төлөвлөгөөг судлах. 50. Агробизнесийн зээл авагчдын байгаль орчны гүйцэтгэлд хяналт тавих. 51. Орон нутгийн удирдлагууд, иргэд болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах; 52. Нүүлгэн шилжүүлэлтийн үр дагавар, нийгмийн сөрөг болон эерэг үр нөлөөг тодорхойлох; 53. Монгол улсын хууль тогтоомж, АХБ-ны Хамгаалалтын бодлогын хүрээнд нүүлгэн	Төсөл хэрэгжих хугацаанд	Үйл ажиллагааны явцын тайлан, сар, улирал, жилийн тайлан	

шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах;		
54. Нүүлгэн шилжүүлэлт хийж буй иргэдэд сэтгэл зүйн болон амьдралын нөхцөлийг сайжруулах дэмжлэг үзүүлэх		
55. Уур амьсгалын өөрчлөлтийг багасгах ухаалаг бэлчээрийн менежментийг сурталчлах, бэлчээрт нүүрстөрөгчийн шингээлтийн хэмжилт хийхэд дэмжлэг үзүүлэх.		
56. Хөдөө аж ахуйн агробизнесийн саналуудын байгаль орчны шаардлагад нийцсэн байдлыг үнэлэхэд дэмжлэг үзүүлэх.		
57. Байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи нэвтрүүлэх талаар зөвлөмж өгөх.		
58. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтэй холбоотой аливаа үр дагавруудыг хянах, хяналтын системийг боловсруулж хэрэгжүүлэх.		
59. Орон нутгийн оролцогч талуудыг уур амьсгалд дасан зохицох, өөрчлөлтийг бууруулах арга хэмжээнд сургаж, байгаль орчны тогтвортой байдлын талаар сургалт семинар зохион байгуулах.		
60. Ногоон гудамж, дэд бүтэц, эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг тусгах талаар зөвлөгөө өгөх.		
61. Оролцогч талуудтай хамтран ажиллах ба харилцах		
62. Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цуглуулах		
63. Нүүлгэн шилжүүлэлт болон газар чөлөөлөлтөд оролцож буй талууд, төрийн болон хувийн байгууллагуудын үүргийг тодорхойлж, үйл явцыг зөв зохион байгуулах		
64. Мэдээллийн нэгдсэн сан бий болгох ба түүний үр ашигтай ажиллагааг хангах;		
65. Газрын чөлөөлөлт хийх үед орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжтэй холбогдох гэрээ, зөвшөөрөл баталгаажуулах;		
66. Гомдол гаргах, шийдвэрлэхтэй холбоотой хууль эрх зүйн орчныг судлах;		
67. Гомдол гаргагчийн мэдээллийг нууцлалтай, аюулгүй байлгах, түүний эсрэг ямар нэгэн хориг арга хэмжээ авахгүй байхыг хангах		
68. Иргэдэд төслийн талаар мэдээлж тэдний санал бодлыг сонсох, хамтран ажиллах;		

		Ур чадвар	Англи, монгол хэлний мэдлэгтэй, олон талын оролцогч талуудтай хамтран ажиллах чадвартай байх.	
--	--	-----------	---	--

Г. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо:


Дугаар:

(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

БАТХҮҮ)

2026 оны ... дүгээр сарын ... -ны өдөр



69.Газар чөлөөлөлт хийхээс өмнө газар эзэмшигчдийн тоо, газар ашиглалтын байдал, хариуцагч талуудын дунд хөрөнгийн хэмжээ болон нийгмийн хэрэгцээ шаардлага зэргийг сайтар судлах. 70.Үйл ажиллагааны хяналт тавих; 71.Газрын чөлөөлөлт эхлэхээс өмнө, хэрэгжилт үеийн явц болон дуусахад хяналт тавих; 72.Газрын чөлөөлөлт, нөхөн төлбөрийн үйл явцад хяналт тавих; 73.Нүүлгэн шилжүүлэлтийн ажиллагааны үеийн газар зүй, байгаль орчны судалгаа хийх		
Тайлбар: Ажил гүйцэтгэх хугацаа, хуваарийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлно.		

В. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх.	
		Мэргэжил	Хүрээлэн буй орчин /052/, Ахуйн үйлчилгээ /101/	
		Туршлага	Байгаль орчны менежментийн чиглэлээр мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай, олон улсын хөгжлийн төслүүдэд ажилласан бол давуу тал болно; Олон улсын байгууллагуудын хамгаалалтын бодлогууд, нүүрстөрөгчийн зах зээл, нүүрстөрөгчийн шингээлтийн хэмжилт, бэлчээрийн менежментийн талаар мэдлэгтэй байх; Орон нутгийн оролцогч талуудтай харилцах, мөн үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор төслийн талбайд ойр ойрхон очиж байх;	